



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дундговь аймгийн Хулд сумын Засаг даргын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ДУА-2026/13/НА-СТА-ТТЗ

Аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: Р.Мөнхтогтох
Утас: 70592439
Цахим хаяг: Munkhtogtokhr@audit.gov.mn

Аудитын менежер: Т.Батсайхан
Утас: 70592225
Цахим хаяг: Batsaikhant@audit.gov.mn

Ахлах аудитор: Ж.Угтахбаяр
Утас: 70593113
Цахим хаяг: Ugtakhbayarj@audit.gov.mn

Аудитор: Э.Пүрэвбаатар
Утас: 70593110
Цахим хаяг: purevbaatare@audit.gov.mn

Цахим хуудас: www.audit.mn

Дундговь аймаг

2026 он

Агуулга

..... 0

1.Аудитын санал дүгнэлт 2

2. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл 5

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан мянган төгрөг 5

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан мянган төгрөг 5

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан мянган төгрөг..... 6

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан мянган төгрөг..... 6

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан мянган төгрөг 7

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан мянган төгрөг 7

3. Аудитын илрүүлэлт 7

4. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл 16

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн хурал
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан

1. Аудитын санал дүгнэлт



ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Нутгийн удирдлагын орлоц, 7-р баг, Сайнцагаан сум
Дундговь аймаг 48090 Утас: 70592439, 70592208,
70593208, Цахим хаяг: dundgovi@audit.gov.mn

2026.02.20 № 96

танай _____ -ны № _____ -т

Хязгаарлалттай дүгнэлт

ДУНДГОВЬ АЙМГИЙН ХУЛД
СУМЫН ЗАСАГ ДАРГА
Ж.ЭРДЭНЭБААТАР ТАНАА

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.3-т заасны дагуу Дундговь аймгийн Хулд сумын Засаг даргын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь материаллаг боловч өргөн тархаагүй гэж үзсэн бөгөөд санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөг эс тооцвол Дундговь аймгийн Хулд сумын Засаг даргын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

1. Засаг даргын тамгын газар нь эрх бүхий албан тушаалтан өөртөө тушаал гарган, төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшууллын зардлаас түлээ нүүрсний хөнгөлөлт олгосон.
2. Хоршоо хөгжүүлэх сан дээр Төсөл хэрэгжүүлэгч аж ахуй нэгжийн 7.8 сая төгрөгийн үндсэн зээл төлөгдөөгүй, гэрээний үүрэг биелүүлээгүй.
3. Орон нутгийн хөгжлийн сангийн санхүүгийн тайланд тусгагдсан харилцагч байгууллагуудын авлагын 33,946.1 мянган төгрөгийн үлдэгдлийг тооцоо нийлж баталгаажуулаагүй, зөрчлийг давтан гаргасан.
4. Сумын засаг дарга нь хуульд заасан эрх мэдлийнхээ хүрээнд удирдлагаар хангах үүргээ биелүүлээгүй, өмнөх аудитаар өгөгдсөн зөрчил арилгуулах албан шаардлагыг бүрэн хэрэгжүүлээгүй, зөрчлийг давтан гаргасан.

Дээрх зөрчлүүд нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, 16.5.1, 16.5.2 дахь заалт, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 11.1 дэх хэсэг, Барилгын тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1.4-т, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5, 20.2.6 дахь заалт, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 71

4826050322

дүгээр зүйлийн 71.1.8 дахь заалт, Иргэний хуулийн 222.4, 222.5 дахь хэсэг, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2021 оны А/361 дүгээр тушаалаар батлагдсан “Хоршоог хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, эргэн төлүүлэх, хяналт тавих журам”-ын 3.4.11-д заасан заалтуудтай тус тус нийцэхгүй байна.

Залруулагдаагүй алдаа нь урьдчилан тооцоолсон материаллаг байдлын түвшнээс 16.6 сая төгрөгөөр их, санхүүгийн тайлан дахь авлагыг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй, эрх бүхий албан тушаалтан өөртөө тушаал гарган тэтгэмж, урамшуулал авсан, зээлдэгч нь гэрээний үүргээ биелүүлээгүй байхад холбогдох арга хэмжээ авч ажиллаагүй зэрэг нь шинж чанар агуулгын хувьд материаллаг, оршин байх, нийцсэн бөгөөд зохистой байх, эрх үүрэг батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Асуудлыг онцолсон хэсэг

Санхүүгийн тайлангийн тухай хэрэглэгчдийн анхаарал хандуулах, ач холбогдолтой зүйлийн талаар тодруулахад Монгол улсын Засгийн газрын шийдвэрээр 2025 оны 01 сарын 01-ээр төрийн албаны үндсэн цалин нэмсэнтэй холбоотой төсөвт байгууллагуудын цалингийн зардал өмнөх оноос 135.0 сая төгрөгөөр өссөн байна. Хулд сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын “Сумын 2025 оны төсөвт өөрчлөлт оруулах тухай” 06/01 дугаар тогтоолоор тайлант онд 491.7 сая төгрөгийн орлогыг орон нутгийн төсөвт төвлөрүүлэхээр батлагдсанаас гүйцэтгэлээр 570.3 сая төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 116 хувиар биелүүлж, 78.6 сая төгрөгөөр орлого давж биелсэн байна.

Уг үйл явцуудыг санхүүгийн тайланд толилуулсан бөгөөд санхүүгийн тайланд толилуулаагүй асуудал гараагүй болно.

Аудитын гол асуудал

Санхүүгийн тайлангийн тухай хэрэглэгчдийн анхаарал хандуулах, ач холбогдолтой зүйлийн талаар тодруулахад 2025 оны сүүлээр төсвийн орлого бүрдэлтэй уялдуулан төсвийг хэмнэлттэй хуваарилж, зарцуулах, төсвийн сахилга батыг чангатгах, төрийн санхүүгийн тогтвортой байдлыг хангах зорилгоор төрийн сангийн дансны гүйлгээний эрхийг хаасантай холбоотой төсөвт байгууллагуудын үйл ажиллагааны зардалтай холбоотой өр төлбөр өсч, өмнөх оноос 33.8 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

Бусад асуудлын хэсэг

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй зохистой гэж үзлээ.

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 9 зорилт, 121 арга хэмжээг хэрэгжүүлэхээс 103 арга хэмжээг хэрэгжүүлж, гүйцэтгэлийн төлөвлөгөөний үнэлгээгээр 85 хувьтай үнэлэгдсэн байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу

илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Р.МӨНХТОГТОХ

2. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

мянган төгрөг

Дансны код	Дансны нэр, төрөл	1. Эхний үлдэгдэл	2. Эцсийн үлдэгдэл
1	1.1 ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	1,239,875.0	1,681,025.7
31	1.1.1 МӨНГӨН ХӨРӨНГӨ	766,420.3	784,901.5
33	1.1.3 АВЛАГА	281,145.8	590,228.3
35	1.1.5 БАРАА МАТЕРИАЛ	157,388.8	204,396.0
36	1.1.6 НӨӨЦИЙН БАРАА	28,000.0	101,500.0
2	1.2 ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,558,053.1	1,832,562.5
39	1.2.2 ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,558,053.1	1,832,562.5
39200	1.2.2.02 Биет хөрөнгө	1,532,611.0	1,808,259.4
39300	1.2.2.03 Биет бус хөрөнгө	25,442.1	24,303.0
3	1 НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН 3=1+2	2,797,928.0	3,513,588.2
4	2.1 НИЙТ ӨР ТӨЛБӨР	52,134.0	85,954.2
41	2.1.1 БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	52,134.0	85,954.2
41300	2.1.1.03 Өглөг	52,134.0	85,954.2
5	2.2 ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	2,745,794.0	3,427,634.0
51	2.2.1 Засгийн газрын хувь оролцоо	2,745,794.0	3,427,634.0
51100	2.2.1.01 Засгийн газрын оруулсан капитал	328,008.3	328,008.3
51200	2.2.1.08 Хуримтлагдсан үр дүн	2,088,309.1	2,770,149.1
51300	2.2.1.09 Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	329,476.6	329,476.6
6	2 ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН 6=4+5	2,797,928.0	3,513,588.2

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

мянган төгрөг

Дансны код	Дансны нэр, төрөл	5. Өмнөх он	6. Тайлант он
I	1.1.1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН	3,351,038.9	2,543,756.0
11	1.1.1.03 ТАТВАРЫН ОРЛОГО	508,945.9	570,288.4
110	1.1.1.03.1 Орлогын албан татвар	422,443.1	397,025.9
1100	1.1.1.03.1.01 Хувь хүний орлогын албан татвар	422,443.1	397,025.9
113	1.1.1.03.3 Хөрөнгийн албан татвар	49,158.3	102,435.9
118	1.1.1.03.8 Бусад татвар, төлбөр, хураамж	37,344.5	70,826.6
12	1.1.1.04 ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,171,360.6	1,973,467.6
120	1.1.1.04.1 Нийтлэг татварын бус орлого	1,170,730.6	234,233.6
121	1.1.1.04.2 Хөрөнгийн орлого	630.0	0.0
122	1.1.1.04.3 Тусламжийн орлого	0.0	1,033,794.1
123	1.1.1.04.4 Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	0.0	705,439.8
13	1.1.1.05 ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,670,732.3	0.0
II	1.1.2 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,424,609.2	1,677,730.4
21	1.1.2.01 УРСГАЛ ЗАРДАЛ	1,424,609.2	1,677,730.4
210	1.1.2.01.1 БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,398,675.3	1,603,163.7
2101	1.1.2.01.1.01 Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	584,848.5	703,117.1
2102	1.1.2.01.1.02 Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	70,745.7	87,480.8
2103	1.1.2.01.1.03 Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	347,516.5	343,319.6
2104	1.1.2.01.1.04 Хангамж, бараа материалын зардал	50,843.2	55,039.5
2106	1.1.2.01.1.06 Эд хогшил, урсгал засварын зардал	69,515.3	91,602.3
2107	1.1.2.01.1.07 Томилолт, зочны зардал	15,851.0	11,589.8
2108	1.1.2.01.1.08 Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	10,678.4	78,078.8
2109	1.1.2.01.1.09 Бараа үйлчилгээний бусад зардал	248,676.7	232,935.8
213	1.1.2.01.4 УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	25,933.9	74,566.7
III	1.1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	1,926,429.7	866,025.6
V	1.2.2 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	1,052,866.5	186,312.4

Дундговь аймгийн Хулд сумын Засаг даргын 2025 оны нэгтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын хураангуй тайлан

VII	1.2 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (VII)=(IV)-(V)	(1,052,866.5)	(186,312.4)
VI	1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(VII)	873,563.2	679,713.2

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

мянган төгрөг

Дансны нэр, төрөл	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Нийт цэвэр хөрөнгө/ өмч
1.1.1.1.1.1 2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,873,876.8	1,873,876.8
1.1.1.1.1.2 Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	(1,646.0)	(1,646.0)
1.1.1.1.1 Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,872,230.8	1,872,230.8
1.1.1.1.7 Тайлант үеийн үр дүн	873,563.2	873,563.2
1.1.1.1 2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,745,794.0	2,745,794.0
1.1.1 2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	2,745,794.0	2,745,794.0
1.1.2 Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	(309.9)	(309.9)
1.1 Дахин илэрхийлсэн үлдэгдэл	2,745,484.1	2,745,484.1
1.3 Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	2,436.6	2,436.6
1.7 Тайлант үеийн үр дүн	679,713.2	679,713.2
1 2025 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	3,427,634.0	3,427,634.0

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

мянган төгрөг

Дансны код	Дансны нэр, төрөл	Өмнөх он	Тайлант он
I	1.1.1.1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	2,405,130.4	2,569,452.3
11	1.1.1.1.03 ТАТВАРЫН ОРЛОГО	508,945.9	570,288.4
110	1.1.1.1.03.1 Орлогын албан татвар	422,443.1	397,025.9
113	1.1.1.1.03.3 Хөрөнгийн албан татвар	49,158.3	102,435.9
118	1.1.1.1.03.8 Бусад татвар, төлбөр, хураамж	37,344.5	70,826.6
1180	1.1.1.1.03.8.01 Бусад нийтлэг төлбөр, хураамж	8,589.6	20,962.0
1181	1.1.1.1.03.8.02 Газрын төлбөр	28,754.9	28,984.6
1182	1.1.1.1.03.8.03 Байгалийн нөөц ашигласны төлбөр	0.0	20,880.0
12	1.1.1.1.04 ТАТВАРЫН БУС ОРЛОГО	225,452.1	1,999,163.9
120	1.1.1.1.04.1 Нийтлэг татварын бус орлого	224,822.1	259,930.0
121	1.1.1.1.04.2 Хөрөнгийн орлого	630.0	0.0
122	1.1.1.1.04.3 Тусламжийн орлого	0.0	1,033,794.1
123	1.1.1.1.04.4 Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	0.0	705,439.8
13	1.1.1.1.05 ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,670,732.3	0.0
II	1.1.1.2 НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,344,812.1	1,572,503.1
21	1.1.1.2.01 УРСГАЛ ЗАРДАЛ	1,344,812.1	1,572,503.1
2101	1.1.1.2.01.1.01 Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	575,239.9	711,911.5
2102	1.1.1.2.01.1.02 Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	70,745.7	87,480.8
2103	1.1.1.2.01.1.03 Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	328,122.3	370,148.0
2104	1.1.1.2.01.1.04 Хангамж, бараа материалын зардал	46,473.7	56,504.9
2106	1.1.1.2.01.1.06 Эд хогшил, урсгал засварын зардал	69,288.8	96,804.0
2107	1.1.1.2.01.1.07 Томилолт, зочны зардал	15,851.0	11,589.8
2108	1.1.1.2.01.1.08 Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	10,678.4	56,754.0
2109	1.1.1.2.01.1.09 Бараа үйлчилгээний бусад зардал	202,478.4	105,935.5
213	1.1.1.2.01.4 УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	25,933.9	75,374.8
III	1.1.1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	1,060,318.3	996,949.2
V	1.1.2.2 ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН	524,830.5	888,468.0
VI	1.1.2 ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(524,830.5)	(888,468.0)

Дундговь аймгийн Хулд сумын Засаг даргын 2025 оны нэгтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын хураангуй тайлан

VIII	1.1	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	535,487.8	18,481.2
101	1.2	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	230,932.5	766,420.3
20	1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	766,420.3	784,901.5

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

мянган төгрөг

Дансны код	Дансны нэр, төрөл	1. Төлөвлөгөө	2. Гүйцэтгэл
1	3.1.01.1 НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	3,170,367.8	2,542,231.8
11	3.1.01.1.1 Татварын орлого	491,660.0	570,288.4
12	3.1.01.1.2 Татварын бус орлого	2,678,707.8	1,971,943.4
II	3.1.01.2 НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	3,170,367.8	2,483,945.6
21	3.1.01.2.1 УРСГАЛ ЗАРДАЛ	1,734,045.8	1,510,827.5
210	3.1.01.2.1.1 БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,643,225.8	1,436,260.8
213	3.1.01.2.1.4 УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	90,820.0	74,566.7
22	3.1.01.2.2 ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	1,300,998.7	883,118.1
23	3.1.01.2.3 ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	135,323.3	90,000.0
230001	3.1.01.2.3.1 Эргэж төлөгдөх зээл	135,323.3	90,000.0
4	4 Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.0	766,420.3
5	5 Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.0	784,901.5

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

мянган төгрөг

Дансны нэр, төрөл	Тайлант он
1.1.1.1 НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	27,220.5
1.1.1.1.1 ТАТВАРЫН БУС ОРЛОГО	27,220.5
1.1.1.1.1.1 Тусламжийн орлого	27,220.5
1.1.1.2 НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	26,412.5
1.1.1.2.1 УРСГАЛ ЗАРДАЛ	26,412.5
1.1.1.2.1.1 БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	26,412.5
1.1.1.2.1.1.3 Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	1,513.3
1.1.1.2.1.1.4 Хангамж, бараа материалын зардал	9,598.7
1.1.1.2.1.1.7 Томилолт, зочны зардал	1,150.0
1.1.1.2.1.1.8 Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	13,149.2
1.1.1.2.1.1.9 Бараа үйлчилгээний бусад зардал	1,001.3

3. Аудитын илрүүлэлт

3.1 Сумын нэгтгэсэн санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн алдаа, зөрчилтэй асуудал

Сумын Засаг даргын 2025 оны нэгтгэсэн санхүүгийн тайлангийн аудитаар алдаа, зөрчил илрээгүй.

3.2 Сумын нэгтгэсэн тайланд нэгтгэгдсэн төсвийн шүүд захирагчдын санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн алдаа, зөрчилтэй асуудал

Сумын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 2 төсвийн байгууллага, 4 тусгай сангийн нийт 6 санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 1 байгууллагад дүгнэлт гаргаж, 1 байгууллага, 4 сан түүвэрт хамрагдсан байна.

Аудитад хамрагдсан Засаг даргын Тамгын газрын санхүүгийн тайланд “Өөрчлөлтгүй” санал дүгнэлт өгсөн байна.

Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл:

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо		Санал дүгнэлтийн хэлбэр
		Аудитад хамрагд	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр	

Дундговь аймгийн Хулд сумын Засаг даргын 2025 оны нэгтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын хураангуй тайлан

			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй	Өөрчлөлтгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
А	1	2	3	4	5	7	8	9	10
1	Засаг даргын Тамгын газар	1	1			1			
2	Иргэдийн Төлөөлөгчдийн хурал	1		1					
3	Мал хамгаалах сан	1		1					
4	Хоршоо хөгжүүлэх сан	1		1					
5	Орон нутгийн хөгжлийн	1		1					
6	Байгаль хамгаалах сан	1		1					
7	Мөнх эрин ногоон говь ОНӨҮГазар	1		1					
	НИЙТ	7	1	6		1			

Харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 434,412.5 мянган төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 8,554.9 мянган төгрөгийн алдааг аудитын явцад залруулж, 8,094.7 мянган төгрөгийн 2 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 417,762.9 мянган төгрөгийн 4 зөрчлийг арилгах албан шаардлагыг тус тус хүргүүлсэн байна.

Аудитаар нягтлан бодогч М.Марал-эрдэнэ нь өмнөх аудитаар өгөгдсөн санхүүгийн тайлан дахь байгууллагаас авах авлагыг харилцагч байгууллагатай тооцоо нийлж, баталгаажуулах зөрчил арилгуулах албан шаардлагыг бүрэн хэрэгжүүлээгүй, засаг дарга Ж.Эрдэнэбаатар нь хуульд заасан эрх мэдлийнхээ хүрээнд удирдлагаар хангаагүй, өмнөх аудитаар өгөгдсөн санхүүгийн тайлан дахь байгууллагаас авах авлагыг харилцагч байгууллагатай тооцоо нийлж, баталгаажуулах болон төсөл, арга хэмжээнүүдэд холбогдох хууль, журмын хүрээнд захиалагчийн хяналтыг хийлгэж ажиллах зөрчил арилгуулах албан шаардлагуудыг бүрэн хэрэгжүүлээгүй, зөрчлийг давтан гаргасан тул хариуцлага тооцох 2 албан шаардлага хүргүүлсэн.

Нийт 425,857.6 мянган төгрөгийн зөрчлөөс нийцлийн аудитын 44,078.5 мянган төгрөгийн асуудал тул 381,779.1 мянган төгрөгийн зөрчлөөс залруулагдаагүй зөрчил нь 11.0 хувь санхүүгийн тайлангийн аудитын зөрчил илэрчээ. Үүнээс аудитын явцад 339,738.4 мянган төгрөгийн авлагын тооцоо нийлсэн актыг баримтжуулж ирүүлсэн.

Харин санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн залруулагдах боломжгүй, аудитын дүгнэлтэд нөлөөлөх 42,040.7 мянган төгрөгийн зөрчил нь тогтоосон материаллаг түвшнээс 16,603.1 мянган төгрөгөөр буюу 1.7 дахин их тул нэгтгэсэн санхүүгийн тайланд “ХЯЗГААРЛАЛТТАЙ” дүгнэлт өгсөн.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл:

/мянган төгрөг/

Байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Хоршоо хөгжүүлэх сан	1	8,554.9			1	8,554.9	1	8,554.9				
Дүн	1	8,554.9			1	8,554.9	1	8,554.9	-	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл:

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Үүнээс				Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
							Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Засаг даргын Тамгын газар	1	294.7	1	294.7								
Орон нутгийн хөгжлийн сан	1	373,684.4			1	373,684.4						
Хоршоо хөгжүүлэх сан	1	7,800.0	1	7,800.0								
Нийт дүн	3	381,779.1	1	8,094.7	1	373,684.4	-	-	-	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал:

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Үүнээс				Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн	
							Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил:												
Орон нутгийн хөгжлийн сан	3	44,078.5			1	44,078.5			2	0		
Нийт дүн	3	44,078.5	-	-	1	44,078.5	-	-	2	0	-	-